



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/16/


Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 он 05 дугаар сарын 05-ны өдрийн босго үнэ шинэчлэн батлах тухай 124 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 27-ны 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн аж ахуйн үйлчилгээний газрын барилгын сантехникийн холболтын ажлын гүйцэтгэгчээр "Их тойн" ХХК-ыг сонгон 16.000.000 /Арван зургаан сая/ төгрөгөөр гэрээ байгуулсугай.
2. Гэрээний дагуу ажлыг чанартай хийж гүйцэтгэж, дуусгахыг "Их тойн" ХХК-ний захирал (А.Эрхэмбаатар)-д даалгасугай.
3. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хот тохижуулах газрын дарга (Д.Очбадрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ